

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХОЙШЛОГДСОН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2020 оны 05-р сарын 04

Хурал эхэлсэн цаг: 11:10

**Хурлаар хэлэлцсэн асуудлууд:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан
3. 2020 оны зорилт, төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай
5. Компанийн хэлбэр өөрчлөх тухай

**Хурлын явц:**

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Нарантуяа: Хурлын дэгийг танилцуулав. Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Хурлын дэгтэй холбоотой санал өгөх гишүүд **Байхгүй** тул хурлын дэгийг батлав.

- Б.Нарантуяа: Тооллогын комиссын даргаар С.Саруултөгсийг сонгох саналтай байна, Та бүхэн ямар саналтай байна?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссоор С.Саруултөгсийг томилох саналыг 100 хувиар зөвшөөрлөө.

Тооллогын комисс ирцийг бүртгэхэд хуралд саналын эрх бүхий 12 263 186 ширхэг хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид буюу 77.28 % ирцтэй байгаа нь компанийн тухай хуулийн 69.1, компанийн дүрмийн 7.4 –ийг хангаж байна. Мөн Компанийн тухай хуулийн 69.3-т заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзэж хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд оруулан тооцсон болно. /Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав./

|                                                                      |                   |
|----------------------------------------------------------------------|-------------------|
| Нийт хувьцааны тоо:                                                  | <b>15 869 233</b> |
| Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр                               | Хувьцааны тоо     |
| Б.Осолгүйгэрэл                                                       | 30 000            |
| С.Баярцэцэг                                                          | 6 000             |
| Б.Цогтгэрэл                                                          | 3 548 345         |
| Ц.Чингүүнболд                                                        | 1 824 000         |
| Ц.Оргилболд                                                          | 912 000           |
| Б.Нарантуяа                                                          | 50 000            |
| Д.Эрдэнэчимэг                                                        | 652 230           |
| “Би Ди Сек ҮЦК” ХК                                                   | 5 240 005         |
| Эм И Ти Эр ХХК                                                       | 596               |
|                                                                      | <b>12 263 176</b> |
| <b>2019 оны 4 – р сарын 05 – ны өдрийн хурлаар ирсэн саналын эрх</b> |                   |
| Ж.Энхтунгалаг                                                        | 10                |
|                                                                      |                   |
| <b>Нийт</b>                                                          | <b>12 263 186</b> |
| <b>Нийт хувьцаанд эзлэх хувь</b>                                     | <b>77,28%</b>     |

Хурлын дэгийн дагуу Хурлын даргыг сонгох асуудал дараагийнх байна, ТУЗ-ийн дарга Б.Цогтгэрэлийг сонгох уу? Хувь нийлүүлэгчдийн 100 хувийн саналаар Б.Цогтгэрэлийг ХЭХ-ын даргаар сонгов.

**Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.**

**Хурлын хэлэлцэх асуудал 1:**

Хурлын дэгийн дагуу Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа: Бид 2019 онд захиргаа санхүүгийн албанд 4, инженер техникийн ажилтан 8, мэргэжилтэй ажилчин-8, машин механизмын-6 үндсэн 4, харуул хамгаалалт, үйлчилгээний-2, нийт 32 ажилтан, ажилчидтай үйл ажиллагаагаа явууллаа..

**Компанийн хэмжээнд дагаж мөрдөх нэн шаардлагатай эрх зүйн баримт бичгүүд болох:**

- "Монинжбар хувьцаат компанийн хөдөлмөрийн дотоод журам"
- "Монинжбар хувьцаат компанийн аюулгүй ажиллагааны журам"
- "Монинжбар хувьцаат компанийн хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны олголт ба ашиглалтын журам"
- "Монинжбар хувьцаат компанийн инженер техникийн ажилтнуудын ажиллах журам"

зэрэг журмуудыг шинээр боловсруулан баталж, нийт ажилчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийт ажилтан, ажилчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 оны 8, 9 дүгээр саруудад мэргэжлийн байгууллагын ХАБЭА-н сургалтад хамруулж, ИТА-нууд туслах ажилчид, харуулуудыг ажлын хувцас, гутал бүрэн хангав.

Өнгөрсөн онд НЗДТГ-ын захиалгаар УБГХХХОДХөтөлбөр төслийн хүрээнд "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метр урттай ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аа амжилттай гүйцэтгэж, 2500 метр шугамын угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Төслийн ажлын газар чөлөөлөлт болон автозамын зөвшөөрөл олгогдоогүйгээс талбайн ажил зогссон бөгөөд трассын дагуу саад бэрхшээлүүд их байгаа боловч бид асуудлыг шийдүүлэн ажиллаж ирлээ. Гэхдээ нийслэлийн харьяа байгууллагуудын уялдаа холбоо муу байгаа нь бидний ажилд гацаа үүсгэж байна.

Үүний улмаас түншлэлийн Н Эй Би ХХК ажлаа эхлүүлээгүй нь бидний санхүүд бас нөлөөлсөн, учир нь төслийн ажилд хэрэглэгдэх шугам хоолой, хуванцар холбох хэрэгслийг зээлийн эх үүсвэрээр бүгдийг үйлдвэрлүүлж, татан авалтаа хийсэн тул зээлийн эргэн төлөлтөд нөлөөлж байна.

ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 04-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн САН ХХК-тай хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулж, конторын барилгыг буулган газар чөлөөлөлт хийгдсэн.

НХХЯ-наас олгодог мэргэжилтэй ажилтан бэлтгэх тодруулбал гагнуурчин, операторчин сургах мэргэжлийн сургалтын зөвшөөрлийг авсан.

**Хурлаар хэлэлцэх асуудал: 2**

Бид өнгөрсөн 2019 онд төслийн ажлын хүрээнд 3 удаагийн гүйцэтгэлээр нийт 2 738, 3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 916,8 сая төгрөгийн зардалтай, 210,6 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа.

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлыг дотор нь ангилж үзвэл цалин хөлс 210.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 31.2 сая, зээлийн хүү болон батлан даалтын шимтгэлд 396.9 сая, албан томилолтын зардалд 10.2 сая, машин механизм, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 40.8 сая, шуудан холбооны зардалд 10.4 сая, ашиглалтын зардалд 8.3 сая, шатах тослох материалын зардалд 5.1 сая, элэгдлийн зардалд 114.9 сая, бусад зардалд 89 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад дансны өглөг нилээдгүй өссөн байгаа нь төслийн ажилд хэрэглэгдэх шугам хоолойн худалдан авалтад зориулан Хаан банкнаас 2.444,4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл, материалын татан авалтын тээврийн зардал, хятад монгол хил гаалийн бүрдүүлэлтэд зориулж Чингис хаан банкнаас 600 сая төгрөгийн зээл авч ажлаа эхлүүлсэнтэй холбоотой.

Өнгөрсөн жил бид НДШ-д 22.1 сая, ХАОАТ-19.2 сая, үл хөдлөх хөрөнгийн татварт 1.6 сая, газрын төлбөрт 5.8 сая, автотээвэр 0.4 сая, 2015 оны татварын хяналт шалгалтын өрөнд 20 сая төгрөг тус тус нийтдээ 69.1 сая төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээ.

Азбаяр: Түншлэлийн Н Эй Би ХХК – ийн гүйцэтгэсэн хувь нь хэд бэ?

Б.Нарантуяа: Түншлэгч Н Эй Би ХХК 2019 оны байдлаар ажил хийгдээгүй байна. Хийгдээгүй байгаа шалтгаан нь Н Эй Би ХХК – ийн гүйцэтгэх трассын дагуу авто зам хуулах,

сэтлэх г.м ажлын тоо хэмжээ нэмэгдсэн асуудлууд шийдэгдээгүй, Нийслэлийн авто замын газраас зам хуулах, сэтлэх зөвшөөрөл өгөөгүйн улмаас нэг метр ч ажил хийгдээгүй.

Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагаа гүйцэтгэлийн хувьд “Хангалттай” гэж үзэж байна. Учир нь хот дотор хүнд трасс саад бэрхшээл их байгаа ч талбайн ажлын гүйцэтгэл сайн явагдсан байна, харин газар чөлөөлөлт, автозамын зөвшөөрөл зэрэг асуудлуудаа цаашид сайн шахаж хугацаа алдахгүйгээр энэ жил ажиллах хэрэгтэй.

Санхүүгийн хувьд Н Эй Би ажлаа хийгээгүйгээс зээлийн эргэн төлөлтөд шууд нөлөөлж байх тул энэ жил эдний ажлыг эрт эхлүүлэх шаардлагатай байна. Олж болох ашгаа зээлийн хүүгийн зардалд төлж байгаа нь учир дутагдалтай байна.

Иймд санхүүгийн үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэлээ.

Гүйцэтгэх захирал 2020 оны төсөв төлөвлөгөөг танилцуулав. 2019 онд санхүүгийн хувьд алдагдалтай гарсан тул төрийн аливаа худалдан авалтад оролцох боломжгүй гэдгийг гүйцэтгэх захирал тайлбарлав, гэсэн хэдий ч хувийн компаниудын хийгдэх ажлаас судалж байгаа гэлгийг толотголоо.

**Б.Цогтгэрэл:** Та бүхнээс 2020 оны төлөвлөгөөтэй холбоотой асуух зүйл байна уу? 2020 оны санхүүгийн төслийг батлах уу.

Бүх гишүүд 100% зөвшөөрч ХЭХ-аас 2020 оны санхүүгийн төслийг зөвшөөрсөн тогтоолыг баталлаа.

**2020 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө**

| Орлогын нэр         | Нийт орлого   | 2020 он       |
|---------------------|---------------|---------------|
|                     |               | Ашиг/алдагдал |
| Тасганы ажил 51.19% | 928,639,136   | -117,499,304  |
| Н Эй Би ХХК         | 2,172,114,254 |               |
| Дүн                 | 3,100,753,410 |               |

**Хурлаар хэлэлцэх асуудал 4**

2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай холбоотой Ногдол ашиг тараах бололцоо байхгүй байгаа тул 2020 оны 01 – р сарын 28 – ны өдрийн ТУЗ19/01 тоот тогтоолоор Ногдол ашиг таарахгүй байх шийвэр гарсан байна./ТУЗ – ийн тогтоолыг танилцуулав/ Компанийн хэлбэр өөрчлөх асуудал дэмжигдээгүй тул хэлэлцсэнгүй.

**Шийдвэрлэсэн нь:**

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэн, 2020 оны үйл ажиллагааг эрчимжүүлэхэд гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх,
- Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалтгүй” гэж үзэж ХЭХ-аас ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад санхүүгийн сахилга батыг сайжруулахад анхаарал тавин ажиллах үүрэг даалгавар өгөх
- Компанийн 2020 оны зорилт, төсвийн төлөвлөгөөг батлах
- Компани 2020 онд Ногдол ашиг таарахгүй байхаар тус тус шийдвэрлэлээ.

**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА

Б.ЦОГТГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Н.Энхчулуун